

Паулын Ром орох аялал

ШИНЭ ГЭРЭЭНИЙ СЕМИНАРЫН ГАРЫН АВЛАГА

Ромын цэргүүд Паулыг болон бусад хоригдлыг бараг 300 хүнтэй усан онгоцонд авчрав. Намрын сүүл сар болж, аймшигт шуурга үе үе дэгдэж байсан тул тэдний аялал удаан, хүнд хэцүү, аюултай байжээ.

Үйлс 27:9–13-ыг уншина уу

Аймшигт шуурганы үеэр усан онгоцыг засаж, ачааг нь хөнгөлөх хэд хэдэн оролдлого хийв.

Үйлс 27:20–26-г уншина уу

Аймшигт шуурганаас 14 өдрийн дараа тэд эх газар бараадахын тулд аз туршсан арга хэрэглэжээ. Далайчид зангуугаа хаяад, усан онгоцыг орхихыг хүсэж байлаа. Учир нь тэд усан онгоц хад мөргөнө гэж бодож байжээ.

Үйлс 27:30–36-г уншина уу

Усан онгоцыг дахин хөнгөлснийхөө дараа тэд усан онгоцыг эрэг тийш газардуулахыг оролдов.

Үйлс 27:41–44-ийг уншина уу